

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Чулуунхороот сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ДОА-2024/05/НА-СТА-ТТЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2024 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn</p>
---------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.03.25 № 323
танай _____-ны № _____-т

ЧУЛУУНХОРООТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА З.ГЭРЭЛТ-ОД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Чулуунхороот сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуунхороот сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засаг даргын тамгын газар нь өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй. Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн бодитой төлөвлөөгүй.

Аудитын гол асуудал

Чулуунхороот сумын 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 75 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12-р сарын 18-ны өдрийн 17/06 дугаар тогтоолоор 92 хувиар үнэлсэн нь бодитой биш байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

011021219

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	735,688.50	653,609.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	356,258.70	297,870.30
33	АВЛАГА	178,021.80	147,274.20
35	БАРАА МАТЕРИАЛ	201,408.00	208,464.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,365,197.10	4,744,132.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,365,197.10	4,744,132.80
39200	Биет хөрөнгө	1,349,733.60	4,729,453.70
39300	Биет бус хөрөнгө	15,463.50	14,679.10
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,100,885.60	5,397,742.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	115,737.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	115,737.90
41300	Өглөг	0	115,737.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,100,885.60	5,282,004.10
51	Засгийн газрын хувь оролцоо	2,100,885.60	5,282,004.10
51100	Засгийн газрын оруулсан капитал	647,471.50	647,471.50
51200	Хуримтлагдсан үр дүн	1,158,154.90	4,339,273.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	295,259.20	295,259.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,100,885.60	5,397,742.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,733,376.70	6,307,084.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	194,652.10	262,280.50
110	Орлогын албан татвар	127,745.70	166,018.90
1100	Хувь хүний орлогын албан татвар	134,730.30	172,989.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-6,984.60	-6,970.20
113	Хөрөнгийн албан татвар	35,670.40	61,028.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж	31,236.00	35,232.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	404,944.70	4,099,887.80
120	Нийтлэг татварын бус орлого	404,944.70	4,099,887.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,133,779.90	1,944,916.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,211,093.80	1,716,531.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,211,093.80	1,716,531.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,389,116.00	1,716,531.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	330,839.80	475,140.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,174.60	60,721.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	373,637.20	31,251.40
2104	Хангамж, бараа материалын зардал	54,547.30	57,685.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,075.00	1,720.70
2107	Томилолт, зочны зардал	5,058.70	10,146.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	330,486.30	557,460.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	233,297.20	522,406.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	821,977.80	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	522,282.90	4,590,553.30
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,923,654.90	1,409,434.70
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,401,372.00	3,181,118.60

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,536,853.10	5,536,853.10
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-34,595.50	-34,595.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,502,257.60	5,502,257.60
9	Тайлант үеийн үр дүн	-3,401,372.00	-3,401,372.00
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,100,885.60	2,100,885.60
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,100,885.60	2,100,885.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,100,885.60	2,100,885.60
19	Тайлант үеийн үр дүн	3,181,118.60	3,181,118.60
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,282,004.10	5,282,004.10

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,520,920.60	2,317,616.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	194,652.10	262,280.50
110	Орлогын албан татвар	127,745.70	166,018.90
1100	Хувь хүний орлогын албан татвар	134,730.30	172,989.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-6,984.60	-6,970.20
113	Хөрөнгийн албан татвар	35,670.40	61,028.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж	31,236.00	35,232.80
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,563.40	821.6
1181	Газрын төлбөр	29,672.60	34,411.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	192,488.60	110,419.80
120	Нийтлэг татварын бус орлого	192,488.60	110,419.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,133,779.90	1,944,916.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,066,955.20	1,390,606.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,066,955.20	1,390,606.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,244,977.40	1,390,606.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,849.00	520,624.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,090.60	66,185.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	371,748.30	32,400.40
2104	Хангамж, бараа материалын зардал	75,645.00	53,438.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,710.00	1,999.70
2107	Томилолт, зочны зардал	5,058.70	10,146.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	208,849.70	494,947.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,026.10	210,864.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	821,977.80	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	453,965.40	927,009.60
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	327,227.60	985,398.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	327,227.60	985,398.00
2200	Дотоод эх үүсвэрээр	327,227.60	985,398.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-327,227.60	-985,398.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-130,000.00	
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	130,000.00	
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-3,262.20	-58,388.40
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	359,520.90	356,258.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	356,258.70	297,870.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,968,402.10	1,799,721.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,122,938.40	1,112,449.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,122,938.40	1,112,449.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	478,951.20	476,739.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,721.40	60,721.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	470,554.60	470,255.60
2104	Хангамж, бараа материалын зардал	34,112.90	31,398.51
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,591.00	9,721.78
2107	Томилолт, зочны зардал	8,138.00	8,138.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,884.90	24,844.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,984.40	30,630.15
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	845,463.70	687,272.05
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,968,402.10	1,744,184.72
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,684,403.10	1,654,250.43
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	283,999.00	89,934.29
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	267,790.99
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	208,519.61

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	542,091.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	228,965.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	199,990.36
2104	Хангамж, бараа материалын зардал	11,143.80
2107	Томилолт, зочны зардал	2,008.06
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,604.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	180,234.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,975.12
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,975.12
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	313,125.99
2200	Дотоод эх үүсвэрээр	313,125.99
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	542,091.47
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	542,091.47

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 137.1 сая төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 2 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

1. Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн сумын төвийн гэрэлтүүлгийн шон худалдан авах байршуулах, орон нутгийн өмчит хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн байр худалдан авах 137.1 сая төгрөгийн 2 ажил огт хийгдээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн мэдээлбэл зохих 177 мэдээллээс 10, 11, 12-р сарын нийт 37 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.4 дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Зөвлөмж

1. Чулуунхороот сумын 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 75 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12-р сарын 18-ны өдрийн 17/06 дугаар тогтоолоор 92 хувиар үнэлсэн байна. Үнэлгээнд ОНХС-ийн хэрэгжээгүй 2 ажил тусгагдаагүй байна. Иймээс үнэлгээг бодитой хийгээгүй байна гэж үзэж байна.

Чулуунхороот сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өгсөн зөвлөмж

Сумын хөгжлийн төлөвлөгөөг үнэн бодитой үнэлж, дүгнэх

2. Малын тоо толгойн албан татварыг 40.0 сая төгрөгөөр төлөвлөж, төвлөрүүлсэн бөгөөд төлөвлөгөөг нь бодитой эсэхэд горим сорил хэрэгжүүлж, тооцож үзэхэд 60.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжтой байна. Орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

Өгсөн зөвлөмж

Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн бодитой тооцож, төлөвлөх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” заалтыг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Чулуунхороот сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ОНХС-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төвийн гэрэлтүүлгийн шон худалдан авах байршуулах, орон нутгийн өмчит хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн байр худалдан авах 2 ажил огт хийгэдээгүй.	1	137.1			1	137.1						
Сумын хөгжлийн төлөвлөгөөг бодитой үнэлээгүй	1	-					1	-				
Малын тоо толгойн албан татварыг бодитой төлөвлөөгүй	1	-					1	-				
Дүн	3	137.1			1	137.1	2	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлбэл зохих 177 мэдээллээс 10, 11, 12-р сарын нийт 37 мэдээллийг огт мэдээлээгүй байна.	1	-			1	-		
Дүн	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	-	-	-	1	-	-	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 01/97 ДОН-2024/05/НА-СТА-ТТЗ
А1170311

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Чулуунхороот сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Төсвийн төвлөрүүлэн захирагчийн мэдээлбэл зохих 177 мэдээллээс 2023 оны 10, 11, 12-р сарын нийт 37 мэдээллийг огт мэдээлээгүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Мөн Төрийн хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах "Ил тод байх" зарчмыг баримтлаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг мөрдөж, ил тод байдлыг хангаж ажиллах, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чулуунхороот сумын Засаг дарга З.Гэрэлт-Од, санхүү албаны дарга Б.Энхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

 И.СЭМЖИДМАА

АУДИТОР

 Б.ОЮУНХЭРЛЭН

011041296



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 02/98 ДДА-2024/05/НА-СТА-ТТЗ
А170311

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Чулуунхороот сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн сумын төвийн гэрэлтүүлгийн шон худалдан авах байршуулах, орон нутгийн өмчит хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн байр худалдан авах, нийт 137.1 сая төгрөгийн 2 ажил огт хийгдээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнг хангаж ажиллах, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чулуунхороот сумын Засаг дарга З.Гэрэлт-Од, санхүү албаны дарга Т.Заяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

 И.СЭМЖИДМАА

АУДИТОР

Б.ОЮУНХЭРЛЭН



011041291